



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

「Улаанбаатар хотын Шуурхай удирдлага,
зохицуулалтын төв ОНӨТҮГ-ын эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 67,815,403.33 (жаран долоон сая найман зуун арван таван мянга дөрвөн зуун гурван төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ (Ч.Ган-Очир)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 3 нэр төрлийн 57,971,650 (тавин долоон сая есөн зуун далан нэгэн мянга зургаан зуун тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдан устгах, 5 нэр төрлийн 9,843,753.33 (есөн сая найман зуун дөчин гурван мянга долоон зуун тавин гурван төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 85,000 (наян таван мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 25,500 (хорин таван мянга таван зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ (Ч.Ган-Очир)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт дотоод аудитын хэлтэст үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор - Эрдэнэ)-д даалгасугай.



ДАРГА ~~М. БАЯРАА~~ М. БАЯРАА

115953300107



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2022 оны 02-р сарын 01-ны өдрийн
A/16 дугаар албан бичгийн хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ

/гөргөөр/

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХК-ын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	Нотебүүк Dell inspron i7	7	ш	1	2,839,900.0	2,839,900.0	2,839,900.0	-	Шуурхай санах ой//CPU/ эх хавтан халалт өгснөөс шалтгаалан гацалт үүсэж асахгүй байгаа.	Сэлбэгэнд зарах	20,000.0
2	Агааржуулагч төхөөрөмж Air condition	7	ш	1	3,363,873.3	3,363,873.3	3,363,873.3	-	Хөргүүрийн компаниудаар перон хэд хэдэн удаа шатахуун шахуулсан боловч богино хугацаанд алдаж перон хадгалах систем гэмтсэн.	Сэлбэгэнд зарах	25,000.0
3	Эйр кондишн Sharp	4	ш	1	3,000,000.0	3,000,000.0	3,000,000.0	-	Хөргүүрийн перон хэд хэдэн удаа шатахуун шахуулсан боловч богино хугацаанд алдаж перон хадгалах систем гэмтсэн.	Сэлбэгэнд зарах	20,000.0
Машин, тоног төхөөрөмжийн дүн					9,203,773.3	9,203,773.3	9,203,773.3	-			
Биет бус хөрөнгө											
1	Виндоус Windows серверийн лиценз	7	ш	7	2,014,870.0	14,104,090.0	14,104,090.0	-	Лицензийн хугацаа дууссан.	Акталж, данс бүртгэлээс хасах	-
2	Дата серверийн лиценз microsoft SQL Serv	7	ш	2	8,403,780.0	16,807,560.0	16,807,560.0	-	Лицензийн хугацаа дууссан.	Акталж, данс бүртгэлээс хасах	-
3	Хадгалах серверд суух Open Stack лиценз	7	ш	3	9,020,000.0	27,060,000.0	27,060,000.0	-	Лицензийн хугацаа дууссан.	Акталж, данс бүртгэлээс хасах	-
Биет бус хөрөнгийн дүн					19,438,650.0	57,971,650.0	57,971,650.0	-			
Бусад үндсэн хөрөнгө											
1	Оффисийн камер 1.3mp	5	ш	1	319,990.0	319,990.0	319,990.0	-	Дүрс дамжуулах боломжгүй болсон.	Сэлбэгэнд зарах	10,000.0
2	Оффисийн камер /CP-UNC-DP10L2C/	7	ш	1	319,990.0	319,990.0	319,990.0	-	Дүрс дамжуулах боломжгүй болсон.	Сэлбэгэнд зарах	10,000.0
Бусад үндсэн хөрөнгийн дүн					639,980.0	639,980.0	639,980.0	-			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн					29,282,403.3	67,815,403.3	67,815,403.3	-			85,000.0
Үүнээс. Худалдах хөрөнгө							9,843,753.3				
Актлах хөрөнгө							57,971,650.0				
Татан төвлөрүүлэн хөрөнгө											
Худалдсанаас олох орлого											85,000.0
НӨХГ-т төвлөрүүлэх /30%/											25,500.0